



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1, 27¹.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Улсын онцгой комиссоос ТОГТООХ нь:

1. "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-т шилжүүлсэн хугацаанд халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн зайлшгүй ажиллах төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг 10 хүртэл хувиар ажиллуулах, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
2. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 5 дугаар сарын 8-ны өдрийг хүртэлх хугацаанд төрийн захиргааны болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ажилтан, алба хаагчдыг ажлын байранд нь ажиллуулахгүй байх арга хэмжээг авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхай, хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтан, алба хаагчдын ээлж солих үйл ажиллагааг зохион байгуулахдаа дараагийн ээлжийн ажилтнуудыг халдвараас урьдчилан сэргийлэх боломжийг бүрэн хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт үүрэг болгосугай.
4. Нийслэлийн хэмжээнд хязгаарлахгүй үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тодорхой цаг, маршрутын дагуу зорчих эрх бүхий QR код олгох замаар хөдөлгөөн зохицуулалтыг өндөр хяналттай зохион байгуулах, холбогдох зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
5. "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-т шилжүүлсэн хугацаанд нийслэл хотод "Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-ыг 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор боловсруулан, баталж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд


Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай.

6. “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацаанд халдварын тархалтыг зогсоох талаар иргэд олон нийтийг уриалах, анхааруулга, халдвараас хамгаалах талаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг тогтмол хүргэж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Соёлын сайд Ч.Номин, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга Ц.Ганзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт даалгасугай.

7. Иргэдийг дархлаажуулалтад хамруулах үйл ажиллагаатай холбогдуулан дархлаажуулалтын цэгүүдэд бөөгнөрөл, эмх замбараагүй байдал үүсгэхгүйгээр хуваарь, төлөвлөгөө гарган байршлыг тодорхой болгож, иргэд олон нийтэд тухай бүр мэдээлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Соёлын сайд Ч.Номин, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга Ц.Ганзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт үүрэг болгосугай.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

УХА0168